

ЭРЭН СУРВАЛЖЛАХ СЭТГҮҮЛ ЗҮЙГ ХӨГЖҮҮЛЭХЭД
ЭРХ ЗҮЙН ОРЧИН НӨЛӨӨЛӨХ НЬ

Г. Солонго*

* МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхмийн магистрант.

Түлхүүр үг: эрэн сурвалжлах сэтгүүл зүй, эрх зүйн орчин, мэдээлэл олж авах эрх, төрийн албан хаагчийн мэдээлэл өгөх үүрэг.

Эрэн сурвалжлах гэсэн нэр томъёог 1990-ээд оноос эхэлж хэрэглэх болсон. Энэ нь монголын нийгэм ардчилалд шилжсэнтэй, мөн чөлөөт сэтгүүл зүйн эх суурь тавигдсантай холбоотой бөгөөд энэ утгаараа эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь манайхны хувьд шинэ ойлголт юм. Гэхдээ монголын сэтгүүл зүйн практикт эл ойлголт огт байгаагүй гэвэл бас өрөөсгөл болно. Харин нэр томъёоны хувьд шинэчлэгдэж, хамрах сэдэв, агуулгын хувьд улам өргөн хүрээг хамрах болсон гэж үзвэл илүү зохимжтой юм.

Эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь ардчилсан болон сэтгүүл зүй өндөр хөгжсөн, эрх зүйн орчин таатай бүрдсэн нөхцөлд илүү эрчимтэй хөгждөг онцлогтой. Ганц жишээ дурдахад л ардчиллын эх орон гэгддэг Америкт бүхэл бүтэн 200 гаруй жилийг туулж байж эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэх анхны алхмаа хийсэн байдаг¹. Ардчилсан нийгэмд тухайн улсын иргэн өөрийн оролцоогоор сонгосон төрийнхөө талаар бүхий л зүйлийг

мэдэж байх, төр өөрөө ч энэ талаар ил тод мэдээлж байх ёстой гэсэн зарчим үйлчилдэг. Өөрөөр хэлбэл парламент, Засгийн газар, шүүхийн мэдээлэл сэтгүүлчдэд нээлттэй байдаг нь тэдний эрж сурвалжлах ажлыг ихэд хөнгөвчилдөг байна.

Манай орны хувьд өнөөдөр УМ-ийн эрх зүйн орчин хүссэн хэмжээнд хүрэхгүй байгаа ч сэтгүүлчийн чөлөөтэй, идэвхтэй үйл ажиллагааг эрс хаасан, хорьсон хуулийн зүйл заалт тун ховор. Гэвч сэтгүүлчийн нэвтэрч болох мэдээллийн хүрээ хязгаарлагдмал байна. Үндсэн хуулинд заасан үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнийхөө хүрээнд зоригтой, шударга ажиллах боломж нөхцөл тааруу байна.

1. Сэтгүүлчийн мэдээлэл олж авах эрх. Мэдээллийн эрх чөлөө буюу төр засгийн талаар мэдээлэл олж авах иргэний болон сэтгүүлчийн эрхийг ардчилал хөгжсөн орнуудад тусгай, бие даасан хуулиар зохицуулдаг байна. Гэтэл ардчилсан гэгдээд байгаа Монгол улсын хувьд бие даасан хууль бүү хэл 1998 оны 8-р сарын 28-нд батлагдсан "Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай" нэртэй билэгдлийн чанартай хуульд сэтгүүлчид мэдээллийн эх сурвалжид нэвтрэх, олсон мэдээллээ олон нийтэд

түгээх, итгэл хүлээн олж авсан мэдээллийн эх сурвалжаа нууцлах, хамгаалах; тэр, түүний байгууллагын мэдээллийг нээлттэй болгох зэрэг олон асуудлыг зохицуулж чадаагүй, энэ талаар нарийн зүйл заалт оруулж өгөөгүй байна. Олон улсын болон бусад орны хууль эрхийн актад мэдээлэл олж авах, хүртэх, мэдээлэл өгөх эрхийн харилцааг зохицуулахад баримтлах үндсэн хэдэн зарчим байгааг ажиглаж болно.

- Иргэдийг төртэй холбох баримт бичиг, мэдээлэлтэй танилцах боломжоор хангах,

- Төр засгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэлд төрөөс тавих хяналтыг аль болох хязгаарлах,

- Улсын нууцтай холбоотой баримт бичгийн жагсаалтыг батлах. Өөрөөр

хэлбэл олон нийтэд хүртээл болгох зайлшгүй шаардлагатай гэсэн үндэслэлийг хувь хүний болон байгууллагын нууц байх үндэслэлтэй адил төвшинд авч үзэх,

- Мэдээлэл олж авах, мэдээлэл өгөх үйл ажиллагааны хэм хэмжээг тодорхойлох. Нэг үгээр хэлбэл мэдээлэл хүртэх хүсэлтээ хэнд яаж гаргах, биелүүлэх хугацаа, зөвшөөрсөн болон татгалзсан талаар албан ёсны хариу өгөх гэх мэтийг тусгах,

- Мэдээлэл өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзсан тохиолдлыг шүүхээр хянуулах эрхээр хангах. Мөн мэдээлэл түгээхэд хэн нэгэнд ялгавартай хандах явдал гаргахгүй

байх зэрэг нийтлэг шинжийг баримталдаг байна.

Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг чөлөөтэй олж авах эрх нь хэвлэлийн эрх чөлөөний салшгүй нэг хэсэг төдийгүй, ардчилсан нийгмийн хөгжлийн үндэс болдог. Тийм ч учраас хэн их мэдээлэлтэй байна, тэр хүчирхэг, эрх мэдэлтэй байна гэсэн үзэл ардчилал хөгжсөн орнуудад давамгайлдаг байна. Төрийн мэдээлэл олж авах иргэдийн

эрх, төрийн мэдээлэлд нэвтрэх сэтгүүлчийн эрхийг ардчилал хөгжсөн ихэнх оронд баталгаажуулсан байна. Үүнд:

- Төр болон түүнтэй холбоотой мэдээллийг олж авах,

- Шүүх хуралдаанд оролцох, түүнтэй холбоотой мэдээллийг нийтлэх эрх,

дээллийг нийтлэх эрх,

- УИХ-ын хуралдаанд оролцох, түүнтэй холбоотой мэдээлэл нийтлэх эрх,

- Хувь хүний нууцын тухайд сэтгүүлчийн энэ эрх нь зөвхөн хувь хүнийх нь хүсэл сонирхол төдий бус, нийгэм, олон нийтийн нийтлэг эрх ашигтай шууд холбоотой. Монгол улсын Үндсэн хуулийн "Мэдээлэл хайх, хүлээн авах" иргэний эрхийг онцгойлон анхаарч, эрх хэмжээг нь өргөжүүлээгүй мөртлөө тус хуулийн "Тусгайлан хамгаалбал зохих нууц" гэсэн тодотгол, "Төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар хамгаална" гэсэн заалтыг тун ч гярхай

«

Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг чөлөөтэй олж авах эрх нь хэвлэлийн эрх чөлөөний салшгүй нэг хэсэг төдийгүй, ардчилсан нийгмийн хөгжлийн үндэс болдог. Тийм ч учраас хэн их мэдээлэлтэй байна, тэр хүчирхэг, эрх мэдэлтэй байна гэсэн үзэл ардчилал хөгжсөн орнуудад давамгайлдаг байна.

»

анзаарч 1995 оны 4-р сарын 18-нд "Төрийн нууцын тухай", 1995 оны 4-р сарын 21-нд "Хувь хүний нууцын тухай", 1995 оны 5-р сарын 16-нд "Байгууллагын нууцын тухай", Төрийн нууцын жагсаалтын хуульчилсан баримт бичгийг баталсан байна. Сэтгүүлчийн ажил үүргийнхээ дагуу мэдээлэл олж авах эрх нэн явцуу байгааг дээрх 3 хуулиас ажиглаж болно. Жишээ нь, 1995 онд баталсан "Байгууллагын нууцын тухай хууль"-ийн 5-р зүйлд: "Байгууллага нууцаа хамгаалах журмыг хууль тогтоомжид нийцүүлэн өөрөө тогтоож мөрдөнө" гэсэн нь төр засаг, түүний харьяа бүх байгууллага, үйлдвэр, аж ахуй, санхүүгийн болон төрийн бус аливаа байгууллага нууцлана гэсэн бүхнээ дур зоргоороо нууцад хамааруулах нөхцөлийг бүрдүүлсэн заалт юм.

2. *Төрийн албан хаагчийн мэдээлэл өгөх үүрэг.* Албан тушаалтны мэдээлэл өгөх үүрэг, тэднээс мэдээлэл авах эрхийг хуульчлах нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Өнөөдөр Монголд мэдээлэл өгөх эсэх нь тухайн байгууллагын үзэмж, мэдээлэл өгч буй албан тушаалтны ааш араншингаас хамаарч байна. Төрийн түшээд болон эрх мэдэл бүхий албан тушаалтан мэдээлэл өгөхгүй, өгөхөөс татгалзсан тохиолдолд хэн ч хариуцлага хүлээхгүй байж болохоор, өөрөөр хэлбэл мэдээлэл өгөх асуудлыг албан үүрэг гэж хуульчлаагүй нь хамгийн том шалтаг болж байна. Нэг ёсондоо олон түмний өмнөөс төр засгийн алба хашиж байгаа хэн нэг албан тушаалтанд тухайн мэдээллийг дамжуулах эрх мэдэл байж, түүнийг нь эрх зүйн хувьд баталгаажуулах ёстой юм. Уг нь Монгол улсын Үндсэн хуулийн 16-

р зүйлийн нэгийн 17-р заалтад мэдээлэл хүртэх хүний түгээмэл эрхийг баталгаажуулахдаа төрийн, байгууллагын, хувь хүний нууцад хамаарахаас бусад мэдээллийг тухайн албан тушаалтан өгөх үүрэгтэй гэж заасан байдаг. Гэтэл тэр үүргийг хэрэгжүүлэх тал дээр зохицуулалт хийгдээгүй, харин ч бүр мэдээлэл өгөхийг хязгаарласан хууль, эрх зүйн актууд батлагдсан нь бий. Тухайлбал, Монгол улсын Иргэний болон Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтүүд, бусад хуулийн заалтуудад "нууцыг задруулбал торгоно", "хэвлэлээр тараагдсан бол ял шийтгэнэ" зэрэг мэдээ баримт олох, өгөхийн эсрэг утга бүхий зүйл их бий. Тодорхой жишээн дээр яривал, 1996 онд батлагдсан "Авилгалын эсрэг хууль"-ийн 2-р бүлгийн 1-р зүйлд "Хөрөнгө орлогын мэдүүлгийн нууц" гэсний 1, 2-рт "Хөрөнгө орлогын нууцыг хамгаалах, түүнийг ил болгох асуудлыг хувь хүний нууцын тухай хуулиар зохицуулна" гэсэн нь чухамдаа хээл хахууль, авилга зэрэг шударга бус замаар хөрөнгө хуримтлуулах, орлого олохыг хувь хүний нууцын халдашгүй эрхэд хамааруулан, тэр тухай мэдээ, баримтыг албан тушаалтан нууцлах болно гэсэн утгаар эрхийг нь баталгаажуулсан байна. Энэ нь шударга бус ямар нэгэн үйлдэлтэй, тэр тусмаа эрх мэдэл, өндөр албан тушаалтай нэгний гэмт үйлдлийг илчлэх, тэр талаарх баримт мэдээллийг сэтгүүлчид, хэвлэлийнхэн олж авах эрхийг нь уг хуулиар хязгаарласан хэрэг юм.

Төр олон нийтийг мэдээллээр хангах үүрэгтэй. Энэхүү үүргийнх нь илрэл бол албан тушаалтны эрхэлж буй ажил албатай холбоо бүхий аливаа мэдээллийг сэтгүүлчид, олон нийтэд өгөх эрх, үүрэгтэй байхыг хуульчилж өгснөөр баталгаажих

учиртай. Мэдээж улсын нууцад хамаарах мэдээллийг үүнд оруулахгүй нь ойлгомжтой. Хүн эрх чөлөөгөө эдлэх хүсэлтэй байхад төр засаг, эрх мэдэлтнүүд түүнийг хязгаарлах сонирхолтой байдаг. Энэхүү хязгаарлалт нь зүй ёсны байхаасаа илүү дур зоргынх байх нь элбэг. Үүний илрэл нь албан тушаалтан аль болохоор мэдээлэл өгөхөөс татгалзаж, нууцлалын хүрээг өргөтгөж, олон түмнээс зай барьсан хуулийн заалтуудыг баталж байгаатай холбоотой гэж хэлэхэд хилсдэхгүй юм.

Төрийн мэдээлэлд нэвтрэх хаалттай, албан тушаалтан мэдээлэл өгөх үүрэггүй буюу сонирхолгүй ийм тогтолцоо үйлчилж байхад сэтгүүлчид мэдээллийг зүй бусаар олж, өөрсдөө түүнийгээ хамгаалж чадахгүй шүүхийн өмнө буруудах тохиолдол олон байдаг. Ер нь албан тушаалтны мэдээлэл өгөх үүрэг, тэднээс мэдээлэл авах эрхийг хуульчлах нь мэдээлэл хүртэх эрх зүйн орчны салшгүй нэг хэсэг мөн. Тухайлбал, Америк, Дани зэрэг Өрнөдийн нэлээд оронд албан тушаалтны мэдээлэл өгөх үүргийг хуульчилсан байдаг. Дани улсад л гэхэд албан тушаалтан сэтгүүлчдийн хүссэн мэдээллийг хэрэв хувийн амьдралтай холбоотой биш бол 10 хоногийн дотор гаргаж өгөх үүрэгтэй. Америкт мөн 14 хоногийн дотор албан тушаалтан мэдээллийг өгөх бөгөөд хэрэв татгалзсан бол хуулийн хариуцлага хүлээх ёстойг давхар баталгаажуулсан байдаг аж.

3. Төрийн зүгээс хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хийж буй зохицуулалт. Сэтгүүлч хүн үнэнийг мэдэх гэсэн олон түмний эрхийг хүндэтгэх үүднээс ажил мэргэжилдээ ханддаг билээ. Тэд үүргээ хэрэгжүүлэхэд дараах нөхцөл байдал сөргөөр нөлөөлж байна гэж үзэх үндэслэл бий.

Төрийн мэдэлд байгаа хэвлэл мэдээллийн хэрэгслүүд,

Сэтгүүлчдэд мэдээлэл өгөхдөө албан тушаалтан хайнга ханддаг байдал,

Мэдээллийн эх сурвалжид нэвтрэхэд гардаг бэрхшээл,

Өөрсдийнх нь мэргэжлийн ур чадвар муу зэрэг байдал.

Эдгээр нь сэтгүүлчийн бодит үнэнийг өгүүлэх, тэнцвэртэй мэдээлэл түгээх үйл ажиллагаанд саад болдог байна. Ер нь ардчилсан төрийн үндсэн шинж нь төрийн аливаа байгууллагын үйл ажиллагаа ил тод байх явдал юм. Энэ нь төрийн хувьд хуулиар хүлээсэн үүрэг бөгөөд үүнийгээ байгууллага бүрт байдаг хэвлэл мэдээллийн албаны албархаг мэдээллээр хязгаарлах бус, хуулиар тогтоосон нууцаас бусад үйл ажиллагаатай сэтгүүлчид, иргэд чөлөөтэй танилцах боломж олгох хэрэгтэй. Үүнээс гадна төр засаг, яамдын хэвлэл мэдээллийн албаны үүрэг нь тодорхойгүй, бүрэн төлөвшиж амжаагүй байдал нь эргээд мэдээлэл олж авах сэтгүүлчдийн ажилд саад болдог байна.

4. Эх сурвалжаа нууцлах, хамгаалах сэтгүүлчийн эрх. Өрнөдийн орнуудад ХМХ-ийн чөлөөт байдлыг дан ганц төрийн дарангуйллыг үгүй болгосноор бус, харин "мэдээлэл олж авах, түүнийгээ бүрэн эхээр нь хэвлэж нийтлэх эрхтэй" гэдэг талаас нь илүү ойлгодог ба энэ талаар хууль эрх зүйн баталгаа ч байдаг³. Жишээ нь, Японд олж авсан мэдээллийн эх сурвалжийн нууцыг хадгалж, хамгаалах бололцоог сэтгүүлчдэд олгосон хуулийн заалт бий. Австри, Франц, Шведэд мэдээллийн эзэн, эх сурвалжтай холбогдох асуултад хариулах буюу энэ талын сорилт шалгалтад орохоос сэтгүүлч татгалзаж болохыг заасан хууль

мөрдөгддөг байна. Мөн Германы ихэнх муж улсын хэвлэлийн хуулиудад мэдээллийн цаад эх сурвалжийн нууцыг хадгалах, хамгаалах заалтууд байгаагаас гадна мөрдөх холбооны хуулинд сэтгүүлчийн мэргэжлийн дагуу олсон мэдээллийг цуглуулах эрхийг хамгаалах заалт хүртэл байдаг ажээ. Гэтэл манай ХМ-ийн эрх чөлөөний тухай хуулинд сэтгүүлчдийн мэдээлэл олж авах арга замын тухай, төр засгийн зүгээс сэтгүүлчдэд мэдээллээ өгөх тухай, сэтгүүлчид ол-

сон мэдээллийнхээ эх сурвалжийг нууцлах тухай ямар ч заалт тусгагдаагүй. Чухал баримт, мэдээллийг олох, түүнтэй холбогдох эх сурвалжаа нууцлах нь аль аль нь эрсдэл ихтэй. Тийм ч учраас эх сурвалжаа нууцлах сэтгүүлчийн эрхийг хамгаалах,

энэ тал дээр холбогдох хуулинд нарийвчилсан заалт оруулах зайлшгүй хэрэгтэй. Монголын нөхцөлд хүн ам цөөтэй учир, ихэнх сэтгүүлчээ таних учраас аливаа ноцтой үйл явлын тухай бичиж буй сэтгүүлчийн ар гэр, ажил амьдралд нь аюул учрах боломж тун их. Ийм байдлаас болоод сэтгүүлчид жинхэнэ овог нэрээ нууцалдаг болсон. Түүнээс гадна тэдний бичсэнийг эрх мэдэл бүхий албан тушаалтан мэдчихвэл дарамт үзүүлэх магадлал их тул ийм нөхцөлд мэдээлэл, баримтын эх сурвалжийг нууцлах эрхийг хуульчлан баталгаажуулах нь үнэхээр чухал юм.

Дүгнэлт

Хэвлэл мэдээллийн чөлөөт байдал, тэр дундаа мэдээллийн эрх чөлөө бол тухайн нийгэмд эрэн сурвалжлах сэтгүүл зүй бүрэн утгаараа хөгжих тулгуур зүйлийн нэг юм. Тиймээс өмнөх хэсгүүдэд дурдсан ажиглалт, баримт, судалгаа, харьцуулалт дээр үндэслэн дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

1. Манай оронд иргэд болон сэтгүүлчдийн мэдээлэл хайх, олох эрхийг хуульчилсан боловч тэрхүү

"мэдээлэл авах эрх", "мэдээлэл олох ажил хэрэг" гэсэн ойлголтын дунд хичнээн их зөрүү байгааг дээрх баримтууд нотолж байна. Өөрөөр хэлбэл авилга, хээл хахууль, мөнгө хаана байна, тэнд хэвлэлийн эрх чөлөө байдаггүй ба тийм нөхцөлд албан үүргээ гүйцэтгэж буй сэтгүүлчид ч айдас

«

Монголын нөхцөлд хүн ам цөөтэй, ихэнх сэтгүүлчээ таних учраас ноцтой үйл явлын тухай бичиж буй сэтгүүлчийн ар гэр, ажил амьдралд нь аюул учрах магадлал тун их. Түүнээс гадна эрх мэдэл бүхий албан тушаалтан дарамт үзүүлэх магадлал ч их тул ийм нөхцөлд мэдээлэл, баримтын эх сурвалжийг нууцлах эрхийг хуульчлан баталгаажуулах нь үнэхээр чухал юм.

»

болгоомжлолын дунд байдаг. Энэ утгаараа Монголд мэдээлэл олж авах эрх зүйн орчин бүрдээгүй байна гэж үзэх үндэслэлтэй юм.

2. Үндсэн хуулиар олгогдсон иргэн болон сэтгүүлчийн төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг дагаж, сахиулахад төрийн хүч, анхаарал хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл нууцтай холбоотой хуулиудыг сэтгүүлч зөрчихгүй нь мэдээж. Гэтэл зөрчихгүй гэхээр эрэн сурвалжлах объектийн хүрээ хязгаарлагдмал болчихдог тал ажиглагддаг. Ийм

учраас нууцтай холбоотой хууль тогтоомж, түүний хориглосон заалтуудын хүрээг багасгаж, тусгай хуулиар нууцалбал зохих зүйлийн жагсаалтыг тусгаж өгөх шаардлагатай.

3. Төрийн аль ч албан тушаалтнаас мэдээлэл хүссэн нөхцөлд ямар ч хэвлэл мэдээллийн хэрэгсэлд, сэтгүүлчдэд заавал гаргаж өгдөг журмыг хуульчилж өгөх. Өөрөөр хэлбэл төрийн ажилтан мэдээлэл өгөөгүй, эсвэл өгөхөөс татгалзсан, мөн тухайн мэдээллийн нууцыг задруулсан зэрэг тохиолдолд хүлээх хариуцлагыг хуулиндаа тусгаж өгөх хэрэгтэй.

4. Эрж хайж олсон чухал мэдээ, мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрхийг албан ёсоор баталгаажуулах. Тухайн цаг үеийн мэдээллийг тэр дор нь авч чадахгүй тохиолдолд дараа нь үнэн бодитойг нь мэдэх боломжгүй байдаг. Үүнээс үзэхэд хүмүүсийн амьдралд хэвлэл мэдээллийн үүрэг, нөлөө ямар их ач холбогдолтой нь харагдаж байна. Иргэдийн мэдэх эрх ч үүнтэй холбоотой.

Мэдээллийн эх сурвалжгүйгээр бодит мэдээлэл байж таарахгүй. Мэдээлэл олж авах эрх зүйн орчингүйгээр хэвлэл мэдээллийн чөлөөт байдал хангагдахгүй. Хэвлэл мэдээллийн чөлөөт байдалгүйгээр эрэн сурвалжлах сэтгүүл зүй хөгжих боломжгүй юм.

Ишлэл

¹ З у л ь к а ф и л ь М. 2002. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй. УБ. Х. 9.

² Монгол Улсын Үндсэн Хууль. УБ. 1992.

³ Олон нийтийн мэдэх эрх, мэдээллийн эрх чөлөө. Глоб Интернетейшнл ТББ. УБ. 1999. Х. 45.

Ашигласан бүтээлийн жагсаалт

- 1 2002. Олон нийтийн мэдэх эрх, мэдээллийн эрх чөлөө. УБ.
- 2 2002. Нэр төр, гүтгэлэг. // "Сэтгүүлч ба хууль" цуврал. №5. УБ.
- 3 З у л ь к а ф и л ь М. 2002. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй. УБ.
- 4 З у л ь к а ф и л ь М. 2003. Дэлхийн сэтгүүл зүйн түүх. XX зуун. УБ.
- 5 З у л ь к а ф и л ь М., Ч о й с а м б а ч 2001. Чөлөөт хэвлэл: өчигдөр, өнөөдөр, маргааш. УБ.
- 6 1999. Мэдээлэл хүртэх эрх зүйн орчин. УБ.
- 7 1993. Олон улсын гэрээ хэлэлцээрийн эмхэтгэл. УБ.
- 8 "Авилгалын эсрэг хууль". // "Төрийн мэдээлэл". 1996. №4.
- 9 "Байгууллагын нууцын тухай хууль". // "Төрийн мэдээлэл". 1996. №7.
- 10 "Хувь хүний нууцын тухай хууль". // "Төрийн мэдээлэл". 1996. №7.
- 11 Э р д э н э т у я а Ю. 1992. Монголын хэвлэл мэдээллийн өнөөгийн байдал УБ
- 11 www.forum.mn

Резюме

В статье рассматриваются такие актуальные вопросы расследовательской журналистики Монголии как правовая среда, право журналистов на информацию, обязанности государственных работников дать информацию журналистам, государственное регулирование СМИ и т.д. На основании исследования практических примеров, автор делает вывод, что право граждан и работников СМИ на информацию, правовая среда журналистики расследований и др. оставляют желать лучшего.